



МОНГОЛ УЛСЫН ГААЛИЙН ЭРСДЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АРГА ЗАМ

Д.Цэндсүрэн,
Н.Батнасан, Доктор (Ph.D),

Абстракт

Улсын хилээр нэвтрэх зорчигч, бараа, тээврийн хэрэгсэлд үр дүнтэй хяналт тавих замаар хуулийг хэрэгжүүлэх, худалдаа ба хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх замаар эдийн засгийн өсөлтийг түргэтгэх гэсэн хоёр үндсэн зорилтын хүрээнд улс орнууд гаалийн байгууллагынхаа үйл ажиллагаанд эрсдлийн удирдлагыг нэвтрүүлэн ашиглаж байна.

Эрсдлийн удирдлага бол шинжлэх ухаан технологийн дэвшил, удирдлагын шинэлэг арга хэлбэрт тулгуурласан гаалийн байгууллагын үйл ажиллагааг үр ашигтай, оновчтой, ухаалгаар удирдах арга хэрэгсэл бөгөөд түүнийг нэвтрүүлснээр цаг хугацаа, хөрөнгө нөөцийн аль алиныг нь хэмнэх боломжтой юм. Бид энэхүү судалгааны ажлын хүрээнд Монгол улсын гаалийн байгууллагын өнөөгийн бүтэц тогтолцоо, хүний нөөц, техник технологи, мэдээллийн системийн нөхцөл байдалд нийцүүлэн эрсдлийн удирдлагыг нэвтрүүлэх боломжуудыг судлан үзлээ.

Удиртгал

Орчин үеийн олон улсын худалдааны өргөжилт нь аль ч орны гаалийн нутаг дэвсгэрт нэвтрэн орж буй бараа, тээврийн хэрэгсэл, зорчигчийн хөдөлгөөнд гаалийн байгууллагаас бүрэн хэмжээгээр хяналт тавьж, тэдгээрийг гаалийн үзлэг шалгалтад бүрэн хамруулах боломжийг хязгаарлах болсон. Энэхүү нөхцөл байдал нь гаалийн байгууллагуудын үйл ажиллагаанд эрсдлийн удирдлагыг нэвтрүүлэх зайлшгүй шаардлагыг бий болгосон. Дээрх нөхцөл байдал ялангуяа гаалийн байгууллагын үндсэн үүрэг функцуудын

нэг болох бараа, тээврийн хэрэгсэл, зорчигчийн хөдөлгөөнд тавих хяналтыг илүү нарийн төлөвлөж, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагыг бий болгов. Түүнчлэн хяналтын объектыг түүвэрлэж сонгох, түүвэртээ хууль зөрчих магадлал өндөртэй хяналтын объектуудыг аль болох хамруулах нь чухал боллоо.

Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагыг ХТЕХ 1994-ийн VIII зүйлд “экспорт, импортын бичиг баримтыг цөөрүүлэх, хялбаршуулах замаар экспорт импортын бүрдүүлэлтийн олон шат дамжлага, бэрхшээлүүд, түүнтэй холбоотой хэрэг зөрчлүүдийг бууруулах явдал ...” хэмээн тэмдэглэсэн байна.

Гаалийн байгууллага бараа, тээврийн хэрэгсэл, зорчигчийн үрсгал хөдөлгөөнд гаалийн хяналтыг хэрэгжүүлэхдээ нэг талаас хууль ёсыг сахиулах, нөгөө талаас орчин үеийн гаалийн байгууллагын үндсэн чиг үүргүүдийн нэг болоод байгаа худалдааг хөнгөвчлөх асуудлын аль алиныг зайлшгүй харгалзан үзэх ёстой. Үүний зэрэгцээ үйл ажиллагааныхаа зардлыг хэмнэж, үр өгөөжийг дээшлүүлэх асуудлыг хамтатган үзэх шаардлагатай.

David Widdowson (2005)-ныхоор гаалийн байгууллагын үйл ажиллагааны хууль сахилтын түвшинг харуулдаг гаалийн хяналт ба худалдааг хөнгөвчлөх асуудлууд хоорондоо эсрэг тэсрэг ойлголтууд биш юм. Тэрбээр худалдааг хөнгөвчлөхийн тулд заавал хяналтыг сулруулах буюу хяналтыг сайжруулахын тулд худалдааны хориг саадыг нэмэгдүүлэх шаардлагагүй гэж үзсэн.

D.Widdowson бүтээлдээ гаалийн удирдлагын

дараахь хэлбэрүүд байж болно гэж үзсэн. Эдгээр нь нэгд, хяналт шалгалт ба худалдааг хөнгөвчлөх асуудлын аль алинд нь өндөр ач холбогдол өгдөг тэнцвэртэй удирдлага; хоёрт, эдгээрийн аль алинд нь ач холбогдол өгч чадахаа больсон алдагдсан удирдлага; гуравт, худалдааг хөнгөвчлөх асуудалд илүү анхаардаг боловч хяналт султай чөлөөт удирдлага; дөрөвт, хяналт чанга боловч худалдааг хөнгөвчлөх асуудлыг орхигдуулсан “улаан” төлвийн удирдлага юм. Удирдлагын эдгээр хэлбэрүүдээс хамгийн шилдэг нь худалдааг хөнгөвчлөх ба хяналт тавих асуудлын аль алинд нь өндөр ач холбогдол өгдөг тэнцвэртэй удирдлага гэж үзсэн. Удирдлагын ийм хэлбэрийг хэрэгжүүлэх үндсэн арга нь эрсдлийн удирдлага болохыг тэрбээр онцлон тэмдэглэжээ.¹

Baker (2002) “Гаалийн байгууллага бүх ачилтыг шалгаснаараа бус харин хууль журмыг зөрчсөнөөр үр дүнд нь худалдаа, үйлдвэрлэл, нийтийн эрх ашигт хохирол учруулж болох аливаа эрсдлийг үнэлж, удирдаж чадах хөтөлбөрийг хөгжүүлж байгаа эсэхээс хамаарч үнэлэгдэнэ.”² гэжээ.

Хэдийгээр эрсдлийг удирдах нь чухал боловч энэ нь үйл ажиллагааг хялбаршуулж, эдийн засгийн хувьд үр өгөөжтэй байх ёстой. Гаалийн байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, эрсдлийн удирдлагын хамаарлыг судалсан өөр нэгэн эрдэмтэн Bilal M. Ayyub гаалийн хяналтын зардал нь эрсдлээс хүлээх алдагдлаас давж гарах ёсгүй гэж үзсэн.³ Эндээс эрсдлийн удирдлагад ашиглаж буй арга хэрэгсэл, үйл ажиллагааны үр өгөөж нь түүнийг хэрэгжүүлэхэд гарч буй зардлаас давж гарч буй эсэхийг зардал үр ашгийн шинжилгээгээр тодорхойлж хэмждэг байх шаардлага гарч ирж байна.

Гаалийн байгууллагын хяналтын үр нөлөөг дээшлүүлж, худалдааг хөнгөвчлөхийн тулд ачилт бүрийг бус харин зөрчил гаргах магадлал өндөртэй тийм ачилтуудыг онилж шалгах нь чухал. Орчин үед гаалийн байгууллагууд эрсдэлтэй бүрдүүлэлтүүдийн онилгоо нь түүвэрлэж сонгох, олон шалгуур үзүүлэлтээр үнэлэх гэх мэт эрсдлийн удирдлагын илүү

боловсронгуй аргуудын хэрэглээг шаардах болсон.

Олон шалгуур үзүүлэлтээр үнэлэх арга нь шийдвэр гаргахад шаардлагатай үзүүлэлтүүдийг эрсдлийн удирдлагын шийдвэр гаргахад шаардлагатай ганц үзүүлэлт болгон нэгтгэж өгдөг шинжилгээний өргөн дэлгэр тархсан арга юм. Олон шалгуур үзүүлэлтээр үнэлэх аргыг уламжлал ёсоор шалгуур үзүүлэлт бүрийн жинг тодорхойлох, жигнэсэн дундаж үнэлгээг тооцох гэх мэт байдлаар ашиглаж ирсэн. Гэвч эдүгээ энэхүү арга нь шийдвэр гаргахад шаардлагатай янз бүрийн шалгуур үзүүлэлтийг нэгтгэж,⁴ эрсдлийн зэрэглэлийг тогтоож, тэрхүү зэрэглэлд нь тулгуурлан эрсдлийн удирдлагын шийдвэрийн хувилбаруудыг гаргаж болохуйц хэмжээнд хүрч хөгжсөн байна.⁵

Бодит амьдрал дээр эрсдлийн удирдлага нь бодлогоо тодорхойлохоос эхлээд гарч болох эрсдлүүдийг тодорхойлох, шинжлэх, үнэлэх, хянаж шалгах, хяналт тавих, эрсдлүүдээс урьдчилан сэргийлэх зэргээр гарч болох эрсдлийг байж болох минимум хэмжээнд хүргэхэд чиглүүлэн явуулж буй бүхий л үйл ажиллагааг хамардаг. Эрсдлийг онилсон хяналтыг хэрэгжүүлэхийн тулд гарч болох эрсдлүүдээ зөв тодорхойлох, шинжлэх, үнэлэх асуудал маш чухал.

“Эрсдлийг онилох арга техникүүд нь жам ёсны дагуу шинэ мэдлэг ба арга барил, мэдээллийн боловсронгуй систем, программ хангамж дээр тулгуурлан явагдах болж, урьд нь гаалийн ажилтны түршлага, мэдрэмж, ойлголтоос хамааралтайгаар явагдаж байсан гаалийн хяналтыг хурдасгасан. Автоматжуулсан эрсдлийн шинжилгээ нь авилгалыг бууруулахад тустай төдийгүй хяналтын объектоо өөрөө шийдэж сонгодог байсан гаалийн ажилтны зүгээс гаргаж болох ялгаварлан гадуурхсан үйлдлүүдийг тойрч гарах боломжийг олгож байна. Энэхүү систем болон программ хангамж нь шаардлагатай бүх мэдээллээ өөрөө цуглуулж, эрсдлийн шинжилгээний тэгшитгэлд оруулан, үр дүнг нь тооцоолон гаргаж байна.”⁶

Гаалийн эрсдлийн удирдлагад сонгон шалгах

1 David Widdowson “Managing risk in the customs context” 2005

2 Baker, S. W. (2002), “Customs risk management program responds to security needs”, Corporate Counsel’s International Adviser, No. 204.

3 Ayyub, B. M. (2003). “Risk Analysis in Engineering and Economics.” Boca Raton:Chapman & Hall/CRC.

4 Williams, A. and Giardina, E. (1993). Efficiency in the Public Sector. The Theory and Practice of Cost-Benefit Analysis. Aldershot: Edward Elgar Publishing Limited.

5 Yoon, K. P. & Hwang, C. L. (1995). Multiple Attribute Decision Making. Beverly Hills: Sage.

6 Danilo Desiderio, Roberto Bergami. “Risk management techniques and their use by Customs” The Journal of Customs and Trade., vol III, number 1., 2011

системийг нэвтрүүлэхийн тулд эрсдлийн шалгуур үзүүлэлтүүдийг нэгтгэн, тэгшитгэлд оруулж, шийдвэр гаргахад шаардлагатай эрсдлийн үнэлгээг гарган авах аргачлалыг боловсруулах шаардлагатай бөгөөд гаалийн эрсдлийн дескриптив статистикаас шийдвэр гаргах статистик шилжих замаар үүнийг шийдвэрлэх боломжтой болохыг Bertrand Laporte, Anne-Marie Geourjon, Rota Graziosi нар өөрсдийн судалгаагаар харуулсан. (Geourjon & Laporte 2005⁷; Geourjon, Laporte & Rota Graziosi 2010⁸, Laporte, 2011⁹)

Монгол улсын гаалийн байгууллагын эрсдлийн удирдлагын өнөөгийн нөхцөл байдал, хөгжлийн чиг хандлага

Далай тэнгисээс алслагдсан байршилтай, аж үйлдвэрийн хөгжлөөр сул дорой Монгол улс гадаад улс орнууд, гадаад худалдаанаас эдийн засгийн хувьд хамгийн өндөр хамааралтай орнуудын нэг юм. Тийм ч учраас эдийн засгийн хөгжлөө түргэтгэх үүднээс Монголын Засгийн газар 1990-ээд оноос хойш эдийн засгийг либеральчлах, худалдаа хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх чиглэлд олон чухал алхмуудыг хэрэгжүүлж ирсэн.

Монголын гаалийн байгууллага үйл ажиллагаандаа эрсдлийн удирдлагыг нэвтрүүлж эхэлсэн хугацааг 2000 оны эхэн үеэс эхэлсэн гэж үздэг боловч түүнээс ч бүр өмнө хууль тогтоомжоор хязгаарласан болон хориглосон барааг хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан зөрчлүүдэд дүн шинжилгээ хийж, зөрчил гаргах магадлал бүхий хяналтын цэгүүдэд өндөр анхаарлаа хандуулан ажиллаж ирсэн болохыг гаалийн байгууллагын тайланд¹⁰ дурьджээ. Ерөнхийдөө Монголын гаалийн байгууллагад эрсдлийн удирдлагыг нэвтрүүлэх үйл явц урт хугацааны туршид, хөгжлийн тодорхой үе шатуудыг дамжин явагдсан болох нь түүхэн баримтуудаас харагддаг.

Монгол улс 1991 онд Барааг Тодорхойлох Кодлох Уялдуулсан Систем /БТКУС/-ийн конвенцид нэгдэж, 1994 оноос уг ангиллыг гадаад худалдааны практикт нэвтрүүлсний зэрэгцээ 1991 онд Дэлхийн Гаалийн Байгууллага /ДГБ/-д элсэж, 1994 оноос ASYCUDA системийг гаалийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлжээ. Барааны ангилал, мэдээллийн системд хийсэн дээрх шинэчлэлүүд нь татвар төлөх барааны ангиллыг олон улсын жишгийн дагуу зөв тогтоох, гаалийн үнэлгээний системийг боловсронгуй болгох, нүүр тулсан харилцааг багасгах замаар авилгалыг бууруулах, худалдааг хөнгөвчлөх, мэдээллийг харилцан солилцох чиглэлд хийсэн томоохон алхмууд байв.

Манай улс 2002 онд GAMAS, 2010 оноос “Гаалийн албаны мэдээллийн систем, Гаалийн гадна талын систем”¹¹ (CAIS & CEPS) -ийг нэвтрүүлж, гаалийн байгууллагуудыг бүхэлд нь хамарсан мэдээллийн цахим сүлжээг байгуулсан.

Улмаар Монгол улс 1997 онд Дэлхийн Худалдааны Байгууллага /ДХБ/-д элсч, 2008 онд “Гаалийн тухай хууль”, “Гаалийн тарифын хууль”-ыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж баталсан нь гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлд хийсэн өөрчлөлт шинэчлэлийн үргэлжлэл нь болсон юм. Хэдийгээр гаалийн удирдах байгууллагын бүтцэд эрсдлийн удирдлагын нэгжийг байгуулж, хүний нөөцийг чадавхижуулах талаар олон чухал арга хэмжээг хэрэгжүүлсэн боловч харамсалтай нь

7 Geourjon, A-M & Laporte, B 2005, ‘Risk management for targeting customs controls in developing countries: a risky venture for revenue performance?’, Public Administration and Development, vol.25, no. 2, pp. 105-13.

Geourjon, A-M, Laporte, B & Rota Graziosi, G 2010, ‘How to modernise risk analysis and the selectivity of customs controls in developing countries?’, WCONEWS, no. 62, pp. 29-31.

8 Geourjon, A-M, Laporte, B & Rota Graziosi, G 2010, ‘How to modernise risk analysis and the selectivity of customs controls in developing countries?’, WCONEWS, no. 62, pp. 29-31.

9 Bertrand Laporte “Risk management systems: using data mining in developing countries’ customs administrations” World Customs Journal, Vol Y, Number 1, 2011

10 1912 онд байгуулагдсан Гаалийн алба нь дотоод, гадаадын иргэдээс ялгаатай хувь хэмжээгээр гаалийн татвар хураадаг байсан ба ноёд, хутагт, хувилгаадын шашны зорилгоор хэрэглэх эд зүйлээс гаалийн татвар авдаггүй байжээ. (МУГЕГ, 2012). Үүнтэй холбоотойгоор шашны гэх гэх нэрийн дор нуун дарагдуулсан татварыг илрүүлж, хуулийн дагуу хариуцлага тооцон ажилладаг байжээ. Төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооны үед мөрдөгдөж байсан гаалийн хууль тогтоомжид “Хилийн чанадаас олон улсын шуудангаар илгээсэн эд зүйлийг хөдөлмөрийн бус ашиг олоход зориулан ашиглаж болохгүй” гэж заасан нь одоогийн хуульд “татвараас чөлөөлөгдсөн барааг зориулалтын бусаар хэрэглэхгүй байх” гэсэн заалттай агуулгын хувьд ойролцоо байна. (Гаалийн хууль, 1973)

11 Орчин үеийн гаалийн байгууллагуудын үйл ажиллагаандаа нэвтрүүлж буй “Эрсдэлийн удирдлага, Өөрөө өөрийгөө үнэлэх систем, Нийлүүлэлтийн шат дамжлага, Эдийн засгийн итгэмжлэгдсэн оператор, Хилийн нэгдсэн зохицуулалттай хяналт” зэрэг хөтөлбөр, системүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд мэдээллийн технологи талаас манай улс бүрэн боломжтой болсон.

Монгол улсын гаалийн эрсдлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох арга зам

гааль, татвар, банк, тээвэр зүүчийн байгууллагуудыг хамарсан мэдээллийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлж чадаагүйн улмаас энэ чиглэлд хийсэн ажлууд үр нөлөө муутай байлаа. Нэгэнт мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж чадаагүй байсан тул мэдээлэлд суурилсан эрсдлийн удирдлагыг нэвтрүүлэх боломжгүй байв. Тиймээс гаалийн байгууллага нэг бүрчилсэн үзлэг шалгалт, бүрдүүлэлтийн дараах шалгалт, давхар хяналтын тогтолцоонд нэлээд ач холбогдол өгч байлаа.

Монголын гааль зардал өртөг өндөртэй, цаг хугацаа шаардсан, үр дүн багатай хяналтын уламжлалт аргуудыг өнөөг хүртэл ашигласаар байгаа нь худалдаа хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх зорилгод нийцэхгүй байгаагаар үл барам гаалийн хэрэг зөрчил илрүүлэлт доогуур түвшинд байх, хүнд суртал газар авах, авилга хээл хахуульд автах, үйл ажиллагааны шат дамжлага олон байх, цаг хугацааг алдагдуулах, экспортлох импортлох үйл ажиллагааны зардал өндөр байх шалтгаан нөхцлийг бүрдүүлсээр байгаа юм.

Өнөөгийн нөхцөлд эрсдлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтыг хэрэгжүүлэхдээ гаалийн хяналтын “ногоон”, “улбар шар”, “улаан” төлөвүүдийг ашиглаж байна. “Улаан” төлвийн хувьд бичиг баримтын болон биет шалгалт хамтдаа хийгддэг бол “улбар шар” төлөвт бичиг баримтын шалгалт, харин “ногоон” төлөв сонгогдсон тохиолдолд гаалийн мэдүүлгийн тодорхой хэдэн хүснэгтүүдийг нягтлан шалгах замаар гаалийн хяналтыг хэрэгжүүлж байна. Эрсдлийн удирдлагын програмын сонгон шалгах системийн сүүлийн 3 жилийн үр дүнг доор хүснэгт № 1-т үзүүлээ.

Хүснэгт 1. Гаалийн хяналтын төлвийн статистик /2012-2014 он/

ОН		Ногоон		Улбар шар		Улаан		Дүн
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо
2012	Экспорт	2 376	3.43	5 264	7.61	61 542	88.96	69 182
	Импорт	10 466	5.10	19 673	9.59	175 047	85.31	205 186
	Нийт	12 842	4.68	24 937	9.09	236 589	86.23	274 368
2013	Экспорт	5 168	7.99	28 714	44.37	30 827	47.64	64,709
	Импорт	10 144	5.09	38 519	19.34	150 541	75.57	199 204
	Нийт	15 312	5.80	67 233	25.48	181 368	68.72	263 913
2014	Экспорт	25 132	10.77	96 284	41.26	111 927	47.97	233 343
	Импорт	930	0.49	16 354	8.65	171 769	90.86	189 053
	Нийт	26 062	6.17	112 638	26.67	283 696	67.16	422 396

Эх сурвалж: Гаалийн байгууллагын үйл ажиллагааны тайлан 2012-2014 он

Одоогийн гаалийн хяналтын системд гаалийн хяналтын объектдоо бус харин гаалийн бүрдүүлэлт хийлгэж буй аж ахуйн нэгжүүдээ төвлөрч, аж ахуйн нэгжүүдийг дээрх төлвүүдэд ангилан хяналтыг хэрэгжүүлж байгаа нь олон тооны шүүмжлэл маргааныг араасаа дагуулах болсон.

Хэдийгээр гаалийн хяналт шалгалтын гурван өөр төлвийг ашиглаж байгаа боловч хилээр нэвтэрч буй нийт экспортын барааны 1/2 хувийг, импортын барааны 9/10 хувийг “улаан” төлөвт оруулан хяналт тавьж байна. Энэ нь гаалийн байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж болон бүтээмжийг бууруулж, гадаад худалдаанд оролцогч талуудын хувьд зардал, цаг хугацааны алдагдлыг үүсгэж байгаа билээ /Хүснэгт № 1/.

Гаалийн хяналтад “улаан” төлөв зонхилж байгаагаас гаалийн ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмж олон улсын дунджаас үлэмж доогуур байгаа төдийгүй ажилтнуудын ажлын ачаалал их, хяналт шалгалтын үр нөлөө тааруухан байна. Хүснэгт № 2-т Монголын гаалийн байгууллагын хөдөлмөрийн бүтээмжийг харуулах үүднээс нэг ажилтанд ногдох гадаад худалдааны эргэлтийг зарим улс орнуудын дундажтай харьцуулан үзүүлэв.

Хүснэгт 2. Гаалийн нэг ажилтанд ногдох гадаад худалдааны эргэлт / сая ам.доллар

Он	Нэг ажилтанд ногдох гадаад худалдааны эргэлт /сая.ам.долл/									
	БНХАУ	АНУ	Япон	БНСУ	ОХУ	Австрали	Казакстан	Монгол	Грузин	Фижи
2010	59.48	57.41	167.78	198.09	10.57	66.78	13.77	5.30	5.57	8.33
2011	72.55	65.00	190.88	238.43	13.49	86.76	21.20	9.04	7.71	9.88
2012	74.08	66.89	187.68	233.37	13.24	89.30	22.80	8.38	8.88	10.75

Монгол улсын гаалийн эрсдлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох арга зам

2013	72.96	63.01	173.42	239.25	14.11	85.46	23.38	7.97	5.91	11.14
2014	75.52	67.22	168.80	239.15	16.00	87.26	21.28	7.92	6.94	15.16
Дундаж	70.92	63.90	177.71	229.66	13.48	83.11	20.49	7.72	7.00	11.05

Эх сурвалж: Монгол улсын ГЕГ-ын жилийн тайлан илтгэлүүд 2012-2014 Дэлхийн банкнаас жил бүр эрхлэн гаргаж буй “Doing business” илтгэлээс үзэхэд “Хил дамнан худалдааны үзүүлэлт”¹²-ээрээ Монгол улс 2010 онд дэлхийн 183 орноос 155-д орсон нь хамгийн сайн, харин 2014 онд дэлхийн 189 орноос 181-д орсон нь хамгийн муу үзүүлэлтүүд юм. “Doing business - 2015”-д манай улс бизнесийн орчны ерөнхий үзүүлэлтээрээ дэлхийн 189 орноос 72-т орсон нь өмнөх оноос 2 байраар ухарсан хэрэг юм. Гэвч хил дамнан худалдааны үзүүлэлтээр өмнөх оноос 8 байраар урагшилж, 16 орныг ардаа орхисон байна. Хэдий тийм боловч хөгжлийн түвшингээр ойролцоо дундаас доогуур орлоготой 48 орноос 47-д орсон нь хил дамнан худалдааны үзүүлэлт тааруухан байгааг илтгэж байна.


Хэдийгээр сүүлийн жилүүдэд зарим нэгэн ахиц дэвшил гарч байгаа боловч эдүгээ Монгол улс экспорт, импортын нэг чингэлгийг тээвэрлэх зардлын үзүүлэлтээр дэлхийн хамгийн өндөр зардалтай орнуудын нэгд тооцогдож, чингэлгийг тээвэрлэх хугацааны үзүүлэлтээрээ сүүл мушгиж байна. Үүнд гаалийн бүрдүүлэлтийг хийхтэй холбоотой зардал, цаг хугацааны үзүүлэлтүүд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг.

Зураг 1. Хил дамнан худалдааны үзүүлэлтээр Монгол улсын эзэлж буй байр



Эх сурвалж: World bank, “Trans-border trade indicators” 2007-2015 ДБ-аас хийсэн судалгааны дүнгээс үзэхэд сүүлийн 3 жилийн дунджаар Монгол улсын хэмжээнд барааг импортлоход дунджаар 44-49 хоног, бараа экспортлоход дунджаар 45-50 хоног зарцуулж байна. Энэхүү судалгаанаас үзэхэд, барааг импортлоход зарцуулж буй нийт хугацааны 38.8-43.2%-ийг барааг дотоодод тээвэрлэх болон боомт терминалд ачиж буулгахад, 52.3-57.1%-ийг импортын бичиг баримтыг бүрдүүлэхэд, 4.1-4.5%-ийг гаалийн бүрдүүлэлт, техникийн хяналт хийхэд зарцуулж байна. Харин экспортын барааны хувьд нийт хугацааны 36.0-40.0%-ийг барааг дотоодод тээвэрлэх болон боомт терминалд ачиж буулгахад, 51.1-56.0%-ийг экспортын бичиг баримт бүрдүүлэхэд, 8.0-8.9%-ийг гаалийн бүрдүүлэлт, техникийн хяналт хийхэд тус тус зарцуулж байна.

Зураг 2. Хил дамнан худалдааны үзүүлэлт, Монгол Улс (2007-2015)



Эх сурвалж: World bank, “Trans-border trade indicators” 2007-2015

¹² Хил дамнан худалдаа хийх үзүүлэлт 2006 оноос гарсан боловч улсуудыг байр эзлүүлээгүй байсан тул 2007 оноос хойш гарсан үзүүлэлтүүдийг харьцууллаа.

Хэдийгээр ачилтад хамрагдах барааны төрөл, тоо, шинж чанараас шалтгаалан гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах хугацаа нь харилцан адилгүй байдаг боловч эрсдлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын тогтолцоог нэвтрүүлэх замаар барааг экспортлох, импортлох хугацааг богиносгох боломжтой юм.

Зураг 3. Гаалийн бүрдүүлэлтэд зарцуулсан хугацаа, зардлын харьцуулалт

Үйл ажиллагаа	Экспорт						Импорт					
	Хугацаа (өдөр)			Зардал (ам.долл)			Хугацаа (өдөр)			Зардал (ам.долл)		
	2012	2013	2014	2012	2013	2014	2012	2013	2014	2012	2013	2014
Бичиг баримтын бүрдүүлэлт	23	28	23	145	145	145	23	28	23	110	110	110
Гаалийн бүрдүүлэлт, техникийн хяналт	2	2	2	160	160	160	4	4	4	150	150	150
Боомт, терминалын ачилт буулгалт	5	5	5	190	190	190	5	5	5	190	190	190
Дотоод тээвэр, ачилт буулгалт	14	14	14	2,250	2,250	2,250	13	13	13	2,500	2,500	2,500
Нийт	44	49	44	2,745	2,745	2,745	45	50	45	2,950	2,950	2,950

Эх сурвалж: World bank, "Trans-border trade indicators" 2013-2015

Монголын гаалийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдлийн удирдлагыг нэвтрүүлэх боломж, түүний нийгэм-эдийн засгийн үр ашиг

Монголын гаалийн байгууллагад эрсдлийн удирдлагыг нэвтрүүлэх боломжийг судлахдаа манай орны гаалийн байгууллагын үйл ажиллагааны онцлог нөхцөл байдалд нийцүүлэн Bertrand Laporte (2011)-ийн боловсруулсан эрсдлийн удирдлагын шилэн сонгох системийг сонгон авлаа. Энэхүү аргачлалын дагуу гаалийн мэдээллийн санд одоо байгаа дескриптив статистик мэдээллийг боловсруулж, уг тооцоололдоо тулгуурлан гаалийн байгууллагын эрсдлийн удирдлагын шийдвэр гаргах аргачлалыг санал болгож байна.

Бид гаалийн байгууллагын хувьд хууль зөрчигдөх магадлалыг "1", хууль зөрчигдөхгүй байх магадлалыг "0" гэж үзсэн ба хилээр нэвтэрч буй экспортын барааны бүрдүүлэлтэд 5, импортод 6 (P_{HS} – барааны ангилал; P_I – импортлогч; P_{CO} – гарал үүслийн улс; P_T – гаалийн хяналтын бүс; P_B – гаалийн зуучлагч; P_{TR} – тээврийн төрөл) шалгуур үзүүлэлтийг сонгон авч, хууль зөрчигдөх магадлалыг нь тооцоолов. Ийнхүү магадлалыг тооцоолсноор тухайн бүрдүүлэлт бүрийн хувьд эрсдлийг нь урьдчилан тооцоолж, хяналтын төлвийг нь урьдчилан тодорхойлох боломжтой болох юм.

Bertrand Laporte-ийн "Эрсдлийн удирдлагын сонгон шалгах загвар"-т эрсдлийн дээрх үзүүлэлтүүдээр регрессийн тэгшитгэлд Probit, Logit, Extreme Value загваруудаар сүүлийн 3 жилд бүрдүүлэлт хийсэн гаалийн мэдүүлгүүдийг ашиглан үнэлгээ хийж, гаалийн хяналтын төлвийг тодорхойлох аргачлалаа боловсруулав.

Гаалийн зөрчлийн талаархи чанарын хоёр төрлийн хариулт ашиглаж хийсэн уг тооцоололд 2012 – 2014 онуудад бүрдүүлэлт хийсэн экспортын 367.2 мянга, импортын 593.4 мянга, нийт 960.7 мянган гаалийн мэдүүлгийн мэдээллийг ашигласан.

$$P_r = \alpha + \beta_1 f q_{\text{шалгуур}1ij} + \beta_2 f q_{\text{шалгуур}2ij} + \dots ij + \beta_N f q_{\text{шалгуур}Nij} + \varepsilon_{ij} \quad (1. 1)$$

Хүснэгт № 4-т Probit, Logit, Extreme Value загваруудаар үнэлсэн регрессийн тэгшитгэлийн үнэлгээний дүнг харуулав.

Хүснэгт 3. Probit, Logit, Extreme Value загварын үнэлгээний харьцуулалт

Independent Variable	Probit			Logit			Extreme Value		
	2012	2013	2014	2012	2013	2014	2012	2013	2014
C	13.83***	13.08***	42.36***	41.88***	40.68***	122.47***	7.36***	6.64***	22.32***
P_{HS}	0.22***	0.35***	-2.93***	0.69**	-1.03***	-6.12***	0.12**	-0.18***	-2.14***
P_I	0.16***	-0.57***	3.89***	0.51***	-1.62***	-7.84***	0.08**	-0.31***	-3.32***
P_T	0.08***	-0.97***	-6.32***	0.23**	-2.58***	-16.79***	-0.04**	-0.58***	-4.29***

P_{CO}	-0.71***	-3.72***	-1.63***	-2.05***	-10.15***	-3.75***	-0.39***	-2.07***	-0.96***
P_B	-0.08***	-7.34***	0.55***	-0.24***	-19.71***	1.15***	-0.05***	-4.12***	0.46***
P_{TR}	-16.43***	-3.4***	-31.85***	-47.35***	-13.02***	-97.61***	-9.03***	-1.40***	-14.38***
Prob (LR statistic)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Number of observation	925770	954641	967318	925770	954641	967318	925770	954641	967318
McFadden R-squared	0.012	0.050	0.322	0.012	0.048	0.298	0.012	0.052	0.349

** - ач холбогдлын зэрэг дунд зэрэг

*** - ач холбогдлын зэрэг өндөр

Бидний хийсэн шинжилгээнээс үзвэл, барааны ангилал болон тээврийн төрөл гэсэн шалгуур үзүүлэлтүүдийн коэффициент 2012 онд Logit, Extreme Value загварт дунд зэргийн ач холбогдолтой, харин импортлогч, барааны ангилал гэсэн шалгуур үзүүлэлтүүдийн коэффициент Extreme Value загварт зөвхөн 2012 онд дунд зэргийн ач холбогдолтой гарсан ба бусад үзүүлэлт бүх онуудад ач холбогдол өндөртэй байв.

Ерөнхийдөө шинжилгээний үр дүн дээрх аргачлалыг тухайн ачилт нэг бүрийн хувьд эрсдлийн магадлалыг нь урьдчилан тооцох замаар бүрдүүлэлтийг нь “улаан”, “улбар шар”, “ногоон” төлвийн алинд нь хамааруулахыг тодорхойлоход ашиглах боломжтойг харууллаа.

Хүснэгт № 5-д бид Probit, Logit, Extreme Value загвараар тооцсон импортын бүрдүүлэлтийн хууль зөрчих магадлал болох P_r -ын тооцооны утга, эдгээр интервалд харгалзах зөрчилтэй болон зөрчилгүй мэдүүлгүүдийн хувийн жинг 0 – 1 хооронд 0.2 алхамтай 5 интервалд тархааж харуулав.

Импортын гаалийн бүрдүүлэлтийн мэдээлэлд

хийсэн энэхүү шинжилгээгээр 2012 онд нийт бүрдүүлэлтийн 0.48%, 2013 онд 0.21%, 2014 онд 0.66% нь зөрчилтэй болох нь тогтоогдсон. Гэтэл гаалийн байгууллага нийт бүрдүүлэлтэд 1.0% хүрэхгүй хэмжээний зөрчлийг илрүүлэхийн 2014 онд импортын бүрдүүлэлтийн 90.9%-ийг “улаан”, 8.9%-ийг “улбар шар” төлөвт оруулан шалгаж, ихээхэн хэмжээний хөрөнгө хүч, цаг хугацааг үр ашиггүй зарцуулсан байна. Probit загвараар хийсэн дээрх тооцоогоор 2014 онд эрсдлийн зэрэглэл хамгийн багатай 0.0 – 0.2 интервалд нийт бүрдүүлэлтийн 62.45%, эрсдлийн зэрэг дунд зэргийн буюу 0.3 – 0.4 интервалд нийт бүрдүүлэлтийн 20.74%, эрсдлийн зэрэг өндөртэй буюу 0.5 – 1.0 интервалд нийт бүрдүүлэлтийн 16.82% нь тус тус оногдож байв. Харин зөрчилтэй бүрдүүлэлтийн тооцоог хийж үзвэл, эрсдэл багатай интервалд 2014 онд нийт зөрчилтэй бүрдүүлэлтийн 7.75%, эрсдлийн зэрэг дунд зэргийн бүлэгт 15.94%, эрсдлийн зэрэг өндөртэй бүлэгт 76.31% тус тус ногдож байлаа. Үүнээс үзэхэд, 2014 оны байдлаар, 10000 бүрдүүлэлт тутамд эрсдлийн зэрэглэл багатай интервалд 8 зөрчилтэй бүрдүүлэлт, эрсдлийн зэрэглэл дунд зэргийн бүлэгт 51, эрсдлийн зэрэглэл өндөртэй бүлэгт 301 зөрчилтэй бүрдүүлэлт ногдож байна.

Хүснэгт № 5. Хууль зөрчих магадлал, эрсдэлийн зэрэглэлээр

Интервал	Эрсдлийн магадлалаар тухайн интервалд иийт мэдүүлгийн эзлэх хувийн жин			Эрсдлийн магадлалаар тухайн интервалд зөрчилгүй мэдүүлгийн эзлэх хувийн жин			Эрсдлийн магадлалаар тухайн интервалд зөрчилтэй мэдүүлгийн эзлэх хувийн жин		
	2012	2013	2014	2012	2013	2014	2012	2013	2014
Probit /нийт бүрдүүлэлтэд эзлэх хувийн жингээр/									
[0.0- 0.2]	21.98	72.42	62.45	21.98	72.39	62.40	0.00	0.03	0.05
[0.2- 0.4]	39.02	25.67	20.74	38.81	25.57	20.63	0.21	0.10	0.11
[0.4- 0.6]	12.37	1.77	13.60	12.31	1.70	13.47	0.06	0.07	0.13
[0.6- 0.8]	21.47	0.10	1.38	21.30	0.09	1.22	0.17	0.01	0.16
[0.8- 1.0]	5.16	0.05	1.84	5.12	0.04	1.62	0.04	0.01	0.22
Дүн	100.00	100.00	100.00	99.52	99.80	99.35	0.48	0.21	0.66

Logit /нийт бүрдүүлэлтэд эзлэх хувийн жингээр/									
[0.0- 0.2]	21.64	72.22	62.63	21.64	72.19	62.58	0.00	0.03	0.05
[0.2- 0.4]	39.71	18.83	3.61	39.50	18.79	3.52	0.21	0.04	0.09
[0.4- 0.6]	11.90	8.62	13.92	11.84	8.59	13.71	0.06	0.03	0.21
[0.6- 0.8]	21.60	0.12	4.81	21.43	0.07	4.65	0.17	0.05	0.16
[0.8- 1.0]	5.15	0.21	5.03	5.11	0.15	4.87	0.04	0.06	0.16
Дүн	100.00	100.00	100.00	99.52	99.79	89.34	0.48	0.21	0.66
Extreme Value /нийт бүрдүүлэлтэд эзлэх хувийн жингээр/									
[0.0- 0.2]	29.59	59.32	42.39	29.59	59.29	42.35	0.00	0.03	0.04
[0.2- 0.4]	28.66	25.34	31.79	28.45	25.28	31.66	0.21	0.06	0.13
[0.4- 0.6]	15.59	13.73	19.80	15.53	13.65	19.51	0.06	0.08	0.29
[0.6- 0.8]	20.99	1.32	4.02	20.82	1.30	3.93	0.17	0.02	0.09
[0.8- 1.0]	5.17	0.29	2.00	5.13	0.27	1.89	0.04	0.02	0.11
Дүн	100.00	100.00	100.00	99.52	99.79	99.34	0.48	0.21	0.66

Гаалийн байгууллага аж ахуйн нэгж, иргэдэд үйлчилдэг төрийн байгууллагынхаа хувьд нэг талаас ил тод, нээлттэй байдлаар ажиллаж, шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэн, өртөг зардал багатай, эдийн засгийн хувьд үр ашигтай хэлбэрээр үйл ажиллагааг явуулж, хуулийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Нөгөө талаас үйлчлүүлэгч аж ахуйн нэгж, иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй, шинэлэг байдлаар үйлчилж, худалдааг хөнгөвчилж, улмаар тэдний сэтгэл ханамжийг өндөр байлгах талаар анхаарах ёстой. Хэдийгээр энэ хоёрыг хослуулахад төвөгтэй боловч бидний санал болгож буй бүрдүүлэлтийн төлвийг сонгох аргачлалыг ашиглан, дээрх зорилтуудын аль алиныг нь хангах чиглэлд тодорхой хэмжээний ахиц дэвшил гаргах боломжтой юм.

Бид өөрсдийн боловсруулсан аргачлалд тулгуурлан гаалийн бүрдүүлэлтийн төлвийг сонгоход магадлалын тооцооллыг ашиглах аргыг нэвтрүүлснээр гарах эдийн засаг, нийгмийн үр ашгийн тооцоог хийлээ. Тооцооны үндсэн үр дүнг хавсралт № 1-т харуулав.

Улс орнуудын туршлагаас үзэхэд, гаалийн байгууллагууд гаалийн нэг ажилтанд ногдох гадаад худалдааны эргэлтийг тооцох замаар үйл ажиллагааныхаа үр өгөөжийг, нэгж бүрдүүлэлтэд зарцуулах хугацаанд гарсан өөрчлөлтөөр худалдааг хөнгөвчлөх чиглэлд хийсэн ахиц дэвшлээ тус тус тодорхойлдог. Бид гаалийн байгууллагын үйл ажиллагааны эдгээр үндсэн үзүүлэлтэд гарсан өөрчлөлтийг тооцохдоо судалгааны дараах эх сурвалжуудыг ашиглав. Үүнд:

- 1) Дэлхийн банкны “Doing business” илтгэлийн “хил дамнанас худалдааны үзүүлэлт” гэсэн хэсэгт тусгасан гаалийн бүрдүүлэлтэд зарцуулсан хугацааны үзүүлэлт¹³;
- 2) Монгол улсын ГЕГ болон АНУ-ын ОУХА-аас 2012 онд хийсэн “Бизнесийг дэмжих санаачилга болон гаалийн байгууллагын хамтарсан судалгаа”-гаар тооцоолсон гаалийн бүрдүүлэлтэд зарцуулсан хугацааны үзүүлэлт¹⁴;
- 3) 2014 онд Монгол улсын ГЕГ-аас ДГБ-ын аргачлалын дагуу хийсэн “Монголын гаалийн байгууллагын судалгаа”-гаар тооцсон гаалийн бүрдүүлэлтэд зарцуулсан хугацааны үзүүлэлт¹⁵.
- 4) Гаалийн бүрдүүлэлтийн талаархи ГЕГ-ын статистик мэдээллийн сан;
Гаалийн байгууллагын мэдээгээр 2014 оны байдлаар Монгол улсын хилээр нэвтэрсэн барааны гаалийн бүрдүүлэлтийн 6.2%-ийг “ногоон”, 26.7%-ийг “улбар шар”, 67.2%-ийг “улаан” төлөвт хийгдсэн байна.

13 World bank “Doing business” 2015 p. Энэхүү судалгаанд гаалийн бүрдүүлэлтийн төлвөөр нь ялгаатай тооцоолоогүй нь бидний санал болгож буй аргачлалын үр дүнг тооцоолох боломжгүй болгож байна.

14 ГЕГ, АНУ-ын ОУХА “Бизнесийг дэмжих санаачилга болон гаалийн байгууллагын хамтарсан судалгаа” 2013 хуудас 3-16.

15 ГЕГ “Монголын гаалийн байгууллагын судалгаа” 2014 хуудас 1-7.

Монгол улсын гаалийн эрсдлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох арга зам

Хүснэгт 5. Магадлалын тооцоонд тулгуурласан хяналтыг хэрэгжүүлснээр гаалийн байгууллагын гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдэд гарах өөрчлөлт

д/д	Гаалийн байгууллагын гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд	Аргачлалыг нэвтрүүлэхээс өмнө	Аргачлалыг нэвтрүүлснээр
1.	Гаалийн нэг ажилтанд ногдох бүрдүүлэлтийн тооны өсөлт / %-иар		
	ДБ, "Бизнес эрхлэхүй 2015"	100.0	100.0
	ГЕГ ба АНУ-ын ОУА-ын хамтарсан судалгаа	100.0	152.7
	ГЕГ-ын 2014 оны судалгаа. "Бүрдүүлэлтийн цаг хугацааны стандарт"	100.0	189.4
2.	Гаалийн нэг ажилтанд ногдох гадаад худалдааны эргэцийн өсөлт / %-иар		
	ДБ, "Бизнес эрхлэхүй 2015"	100.0	100.0
	ГЕГ ба АНУ-ын ОУА-ын хамтарсан судалгаа	100.0	152.7
	ГЕГ-ын 2014 оны судалгаа. "Бүрдүүлэлтийн цаг хугацааны стандарт"	100.0	189.4
3.	Экспортын гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах хугацаа /хоногоор		
	ДБ, "Бизнес эрхлэхүй 2015"	4 хоног	4 хоног
	ГЕГ ба АНУ-ын ОУА-ын хамтарсан судалгаа	1.34 хоног	1.12 хоног
	ГЕГ-ын 2014 оны судалгаа. "Бүрдүүлэлтийн цаг хугацааны стандарт"	0.61 хоног	0.41 хоног
4.	Импортын гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах хугацаа / хоногоор		
	ДБ, "Бизнес эрхлэхүй 2015"	4 хоног	4 хоног
	ГЕГ ба АНУ-ын ОУА-ын хамтарсан судалгаа	1.11 хоног	0.42 хоног
	ГЕГ-ын 2014 оны судалгаа. "Бүрдүүлэлтийн цаг хугацааны стандарт"	0.83 хоног	0.33 хоног

Бид 2014 оны гаалийн бүрдүүлэлтийн статистик мэдээлэлд хийсэн шинжилгээндээ тулгуурлан зөрчилтэй бүрдүүлэлт хийх магадлал багатай интервалд байгаа барааг "ногоон", дунд зэргийн интервалд байгаа барааг "улбар шар", өндөр интервалд байгаа барааг "улаан" төлөвт хяналтыг хэрэгжүүлэхээр тусган, үр дүнг харуулав /Хүснэгт 1/. Тооцоонд "улаан" төлөвт шалгах хувь хэмжээг бууруулан, нийт бүрдүүлэлтийн 20.0%-ийг "улаан", 20.0%-ийг "улбар шар", 60.0%-ийг "ногоон" төлөвт хяналтыг хэрэгжүүлэхээр тусгасан болно.

Гаалийн бүрдүүлэлтийн зөрчил гаргах магадлалын тооцоонд тулгуурлан хяналтын төлвийг тогтоох замаар байгаа оносон, оновчтой бөгөөд ухаалаг хяналтыг хэрэгжүүлснээр гаалийн байгууллага одоогийнхоос илүү их бараа, зорчигч, тээврийн хэрэгсэлд хяналт тавих боломжтой юм. Гаалийн байгууллагад үр ашиггүй байдлаар зарцуулагдаж буй нөөцийг багасгаж, хэмнэгдсэн нөөц хүчийг зорчигч болон тээврийн хяналтад шалгалтад шилжүүлэх замаар гаалийн байгууллагын үйлчилгээг бүхэлд нь сайжруулах, худалдаа хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх, хууль сахилтыг дээшлүүлэх боломжийг бүрдүүлж чадна. Нөгөө

талаас гаалийн байгууллагаар үйлчлүүлэгч аж ахуйн нэгж, иргэдийн цаг хугацааг хэмнэх, үйлчилгээний чанарыг сайжруулах, татан авах ба нийлүүлэх хугацааг богиносгох замаар бараа эргэцийг хурдасгаж, бизнесийн үр ашгийг нь дээшлүүлнэ.

Дүгнэлт:

Эрсдлийн удирдлагад суурилсан, оновчтой, ухаалаг хяналтын тогтолцоог бий болгох нь гаалийн байгууллагын өмнө тавигддаг хууль сахилтын түвшинг дээшлүүлэх, худалдааг хөнгөвчлөх гэсэн үндсэн зорилтуудыг хамтад нь хэрэгжүүлэх үндсэн арга зам юм. Ийм оновчтой бөгөөд ухаалаг тогтолцоог бий болгохын тулд магадлалын тооцоонд үндэслэсэн хяналтын тогтолцоог бий болгох шаардлагатай. Нөгөө талаас эрсдэлд суурилсан гаалийн хяналтын тогтолцоо бол орчин үеийн гаалийн байгууллагын шинэчлэлийн гол чиглэл юм.

Эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бий болгох үүднээс бидний санал болгож буй аргачлал нь нэг талаас гаалийн байгууллагын нөөц хүчийг үр дүнтэй ашиглах, гаалийн ажилтнуудын бүтээмжийг дээшлүүлэх, хяналтын

тогтолцоог боловсронгуй болгох замаар хууль сахилтын түвшинг дээшлүүлэх, нөгөө талаас нүүр тулсан харилцааг багасгах, гаалийн байгууллагын үйл ажиллагааг хялбаршуулах, хурдан шүүрхай болгох замаар харилцагчдынхаа үйл ажиллагааны зардал, бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацааг хэмнэх замаар худалдааг хөнгөвчлөх үндсэн зорилготой.

Байгаа оносон оновчтой хяналтын тогтолцоо нь гаалийн байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүхэлд нь сайжруулж, зардлын болон цаг хугацааны хэмнэлтийг бий болгоно гэдэг нь бидний хийсэн судалгаагаар нотлогдож байна.

Эрсдэлд суурилсан гаалийн удирдлагын үр дүнтэй тогтолцоог бий болгохын тулд эрсдлийн удирдлагын үйл ажиллагааг байгууллагын хөгжлийн стратегитэй уялдуулах, эрсдлийн удирдлагын албаны судалгааны чадавхийг бэхжүүлэх, ажилтнуудыг чадавхижуулах, компьютержсэн шилэн сонгох системийг нэвтрүүлэх, дагалдах программ хангамжийг хөгжүүлэх, дотоод аудит болон бүрдүүлэлтийн дараахь хяналт шалгалтыг эрсдлийн удирдлагын үйл ажиллагаатайгаа нягт уялдуулах гэх мэт олон ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлэх шаардлагатай байгаа юм.

Ном зүй:

- Alan Williams, Emilio Giardina., 1993. Efficiency in the Public Sector: The Theory and Practice of Cost-Benefit Analysis, Illustrated, reprint, E. Elgar Pub. California.
- Ayyub B. M, 2014. Risk Analysis in Engineering and Economics, second ed. Chapman and Hall/CRC.
- Baker S. W, 2002. Customs risk management program responds to security needs, Corporate Counsel's International Adviser, No. 204.
- General Customs Administration of Mongolia, USAID Business plus initiatives, 2013. Business plus initiatives and Mongolian Customs Administration report, Ulaanbaatar: USAID, BPI, Mongolia.
- Geourjon, A-M & Laporte., 2005. 'Risk management for targeting customs controls in developing countries: a risky venture for revenue performance?', Public Administration and Development, vol. 25, no. 2, 105.
- Laporte B, 2011. Risk management system:

using data mining in developing countries' customs administrations, World Customs Journal, Volume 5, Number 1, 17-27.

- Luck the Wulf, Jose B Sokol., 2005. Customs Modernization Handbook, Washington: Publication of the World Bank.
- Ndonga D, 2013. Managing the risk of corruption in Customs through single window system. World Customs Journal, Volume 7, Number 2, 23-38.
- General Customs Administration of Mongolia, 2014. Customs Statistic Information, General Customs Administration of Mongolia. Ulaanbaatar: Customs publishing unit.
- WB, 2015. Doing business 2015, Trading across border. Washington: World Bank.
- WCO, 2000. Guidelines on Customs Control. Kyoto Convention-General Annex-Chapter 6, "Guidelines on Customs Control". Belgium, Brussels: WCO.
- WCO, 2010. Background Paper on Risk Management. World Customs Organization Risk Management Forum, 28-29 June 2010, Brussels, Belgium pp. 1-11. Brussels: WCO.
- Widdowson D, 2003. Intervention by Exception: A Study of the Use of Risk Management by Customs Authorities in the International Trading Environment. Canberra: University of Canberra.
- Widdowson D, 2011. Managing risk in customs context. In, Customs modernization hand book (pp. 91-99). Washington: World Bank publisher.
- WTO, 1994. Article VIII of the GATT. Washington: WTO.

ХАВСРАЛТ

Хавсралт № 1. Гаалийн бүрдүүлэлтэд эрсдлийн удирдлагын аргыг нэвтрүүлснээр гарах эдийн засаг, нийгмийн үр өгөөж

Гаалийн хяналтын төлөв	Экспортын бүрдүүлэлт /өдөр/				Импортын бүрдүүлэлт /өдөр/				Нийт хугацаа /өдөр		Шаардагдах ажилтны тоо /өдөр			
	Бүрдүүлэлтийн тоо		Нийт хугацаа /өдөр		Бүрдүүлэлтийн тоо		Нийт хугацаа /өдөр		2014 оны байдлаар		2014 оны байдлаар			
	2014 оны байдлаар	шинэ оргочлолоор	Нэг бүрдүүлэлтийг хийхэд зарцуулах хугацаа /өдөр	2014 оны байдлаар	шинэ оргочлолоор	2014 оны байдлаар	шинэ оргочлолоор	Нийт хугацаа /өдөр	2014 оны байдлаар	шинэ оргочлолоор	2014 оны байдлаар	шинэ оргочлолоор		
1*			2.00	50264.0	280008.0			4.00	3720.0	453724.0	53984.0	733732.0	207.1	2814.3
Ногоон	25132	140004	0.97	24294.3	135337.2	930	113431	0.21	199.6	24340.4	24493.8	159677.6	93.9	612.5
2**			0.27	6660.0	37101.1			0.17	161.6	19708.6	6821.6	56809.7	26.2	217.9
3***			2.00	192568.0	93338.0			4.00	65416.0	151244.0	257984.0	244582.0	989.5	938.1
Улбар шар	96284	46669	1.10	105992.6	51374.8	16354	37811	0.26	4190.7	9689.1	110183.3	61063.9	422.6	234.2
3			0.38	36507.7	17695.3			0.23	3768.2	8712.3	40275.9	26407.6	154.5	101.3
1			2.00	223854.0	93338.0			4.00	687076.0	151244.0	910930.0	244582.0	3494.0	938.1
Улаан	111927	46669	1.62	181415.0	75642.7	171769	37811	1.20	205407.1	45215.7	386822.1	120858.3	1483.7	463.6
2			0.88	98868.9	41224.3			0.90	153876.4	33872.4	252745.2	75096.6	969.4	288.0
3				466686.0	466684.0				756212.0	756212.0	1222898.0	1222896.0	4690.6	4690.6
Нийт дүн	233343	233343		311701.9	262354.7	189053	189053		209797.4	79245.1	521499.3	341599.8	2000.3	1310.2
				142036.5	96020.7				157806.2	62293.3	299842.7	158313.9	1150.1	607.2

1* - WB, 2015. Doing business 2015, Trading across border. Washington:

2* - ГЕГ ба АНУ-ын ОУА-ын хамтарсан судалгаа, "Бизнесийг дэмжих санаачилга болон гаалийн байгууллагын хамтарсан судалгаа"

3*** - ГЕГ-ын 2014 оны судалгаа, "Бүрдүүлэлтийн цаг хугацааны стандарт"